



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 8/2/18

Улаанбаатар хот

“Баянзүрх дүүргийн Иргэдийн
төлөөлөгчдийн хурлын ажлын албаны
хөрөнгийг данснаас дансанд шилжүүлэн бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан 22,812,900.00 /хорин хоёр сая найман зуун арван хоёр мянга есөн зуу/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг холбогдох дансанд шилжүүлэн бүртгэхийг Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын алба /П.Сумъяасүрэн/-д зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын алба /П.Сумъяасүрэн/-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

115070000541

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын
2020 оны 05 дугаар сарын 22 ны өдрийн
01/218 тоот тушаалын хавсралт

Данснаас дансанд шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баян Зүрх Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

төгрөгөөр

д/д	Хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт, хүчин чадал	Үйлдвэрлэсэн он	Ашиглалтанд орсон огноо	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх анхны		Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Дансны нэр	
									Нэгж үнэ	Нийт үнэ			Шилжүүлэх данс	Бүртгэх данс
Машин, тоног төхөөрөмж														
1	Canon EOS 7D	Canon EOS 7D	18.0 megapixel CMOS sensor, 1080p HD	2013	2014.06.24	Муу	Ш	1	2,472,870.00	2,472,870.00	2,472,870.00	-	Тавилга эд хогшил	Машин тоног төхөөрөмж
2	Canon lens дуран	Canon Lens EW-88C	24-70mm ultrasonic	2013	2014.06.24	Муу	Ш	1	3,699,540.00	3,699,540.00	3,699,540.00	-	Тавилга эд хогшил	Машин тоног төхөөрөмж
3	Ус шүүгч	Korea Water Care	3 давхар шүүлтүүртэй, халуун, хүйтэн ус гарна. Хар өнгөтэй	2016	2017.03.28	Муу	Ш	1	750,000.00	750,000.00	225,000.00	525,000.00	Тавилга эд хогшил	Машин тоног төхөөрөмж
4	Ус шүүгч	Korea Water Care	4 давхар шүүлтүүртэй, халуун, хүйтэн ус гарна. Цагаан өнгөтэй	2018	2019.03.27	Муу	Ш	1	1,336,500.00	1,336,500.00	33,412.50	1,303,087.50	Тавилга эд хогшил	Машин тоног төхөөрөмж

5	Тоос сорогч	Япон	220в 2800ватт чадалтай,6 метр уугатай	2020	2020.01.02	Муу	Ш	1	229,990.00	229,990.00	-	229,990.00	Бусад хангамжийн материал	Машин тоног төхөөрөмж
6	Халаагч тень	Хятад	Цахилгаан халаагуур 220в, 6- 30мкв талбайг халаана, хэмжээ 60*80*10, жин 4 5 кг	2020	2020.01.02	Дунд	Ш	31	220,000.00	6,820,000.00	-	6,820,000.00	Бусад хангамжийн материал	Машин тоног төхөөрөмж
Машин, тоног төхөөрөмжийн									8,708,900.00	15,308,900.00	6,430,822.50	8,878,077.50		
Тавилга, эд хогшил														
1	Бичгийн самбар	Хятад	1.90*1.10см хэмжээтэй, шохой, маркераар бичдэг	2015	2016.02.16	Дунд	Ш	28	268,000.00	7,504,000.00	4,189,729.88	3,314,270.12	Машин тоног төхөөрөмж	Тавилга эд хогшил
Тавилга, эд хогшлын дүн									268,000.00	7,504,000.00	4,189,729.88	3,314,270.12		
Нийт дүн									22,812,900.00	10,620,552.38	12,192,347.62			